



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрчим хүчний дулааны төв шугамын шинэчлэлт, их засвар, өргөтгөл (Улаанбаатар)-ийн багц-1 буюу дулааны 9А магистралийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын ажлын хүрээнд бий болсон 15 нэрийн нийт 3,973,198,646.00 (гурван тэрбум есөн зуун далан гурван сая нэг зуун ерэн найман мянга зургаан зуун дөчин зургаан) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд тус тус бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, Эрчим хүчний хөгжлийн төвийн захирал Я.Нямжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001285

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн
358 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР АШИГЛАЛТАД ОРСОН,
ЭРЧИМ ХҮЧНИЙ АШИГЛАГЧ КОМПАНИУДЫН ДАНСАНД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Хүчин чадал		Балансын үнэ (төгрөг)	Ашиглагч хуулийн этгээдийн нэр
			Хэмжих нэгж	Биет хэмжээ		
1	Ган хоолой Ф1000мм	Q345B	у/м	2432	2,244,824,096.00	"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компани
2	Ган хоолой Ф700мм	Q345B	у/м	534	289,831,524.00	
3	Ф700 Бөмбөлгөн хаалт	МКФМ	шир	2	42,421,418.00	
4	Ф400 Бөмбөлгөн хаалт	LD	шир	2	13,675,918.00	
5	Ф300 Бөмбөлгөн хаалт	LD	шир	8	25,079,449.00	
6	Ф200 Бөмбөлгөн хаалт	LD	шир	4	7,532,507.00	
7	Ф500-Ф700 Ган шилжвэр	Q345B	шир	2	1,680,641.00	
8	Ус буулгах худаг	КС-15	иж бүрэн	5	5,177,926.00	
9	Төмөр хийц	Т144, Т 2008	иж бүрэн	130	122,449,010.00	
10	Травесс	Т1	шир	130	268,271,695.00	
11	Бетон тулгуур	Б1,Б2, Б3, Б4	шир	22	201,434,512.00	
Дүн					3,222,378,696.00	
1	Ган хоолой Ф1000мм	Q345B	у/м	103	100,522,911.00	"Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компани
2	Ф1000 Бөмбөлгөн хаалт	ТКФМ	шир	4	591,189,402.00	
3	Ф1000 Дулааны тоолуур	Гобой-5	иж бүрэн	2	31,612,000.00	
4	Тулгуур	Т 2008 Б1	иж бүрэн	9	27,495,637.00	
Дүн					750,819,950.00	
3,973,198,646.00						
НИЙТ ДҮН						(гурван тэрбум есөн зуун далан гурван сая нэг зуун ерэн найман мянга зургаан зуун дөчин зургаан төгрөг)